



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/600

Хэрлэн сум

Тайлан хэвлүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хэвлүүлж, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангахад 16,400,000 (арван зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Иргэдийн оролцоот хэтийн Хэнтий" арга хэмжээний зардлаас 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийг, Хяналт, шинжилгээний үнэлгээний зардлаас 15,000,000 (арван таван сая) төгрөгийг тус тус санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 11 дугаар сарын 29-ны
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДАЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайлангийн сэтгүүл	2000	8200	16,400,00
	Нийт үнэ			16,400,00